

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Том. XXX (318)

2009

109-111

МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАХЫН ТИЙН ЯЛГАЛЫГ ТҮРЭГ  
ХЭЛНИЙХ ЛҮГЭЭ ХАРЬЦУУЛАХ НЬ

М.Ууганбаяр<sup>1</sup>

Монгол хэлний гаражын тийн ялгалын үүсэл гарлыг түрэг хэлнийх лүгээ харьцуулан шинжлэхэд юуны өмнө монгол хэлний гаражын тийн ялгалын хэлбэрийг түрэг хэлний тохирох жишээ баримттай дүйлгэн үзэх ёстой болно. Монгол хэлний гаражын тийн ялгал нь хэд хэдэн хувилбартай байдаг бөгөөд эртний болон дундад зууны монгол хэлнээ -ча -аца -dača гэсэн бие даасан нөхцөл, -nača хэмээх ярианы хэлний нөлөөгөөр юм уу үе тусгаарлах зорилгоор үүссэн -uyača -yasa хувилбар хэрэглэгдэж байсан байна. Харин -dača -deče хэлбэрийг судлаачид орших гаражын давхар тийн ялгал гэж тэмдэглэсэн байна. (Поппе 1937: 61; Санжеев 1953: 177; Төмөртогоо, Дамдинжав 1967: 50; Зоригт 2001: 184) Жишээлбэл,

Olon-ča dotun-a soyurqaydaysan ajuu (Cleawes 1949:6: Төмөртогоо Дамдинжав 1967: 50)

Horilartai mergen-u Bargujin hoa -ča torekseen Alan hoa neretei okin tere (Haenisch 1951: 36,

Төмөртогоо Дамдинжав 1967: 50)

Qitad-un ayalgus-ača mongyol-un ayalgus-tur nayirayulyan orčiyuluγadü (Cleawes 1951:36; Төмөртогоо Дамдинжав 1967: 50)

Činggis hahan-u hujaur de`ere tenggeri-eče jaya`atu törekseen Börte čino aju`u (Haenisch 1962&1; Төмөртогоо Дамдинжав 1967: 50)

Edüge nögüge yirtinču deče nökčigsed-un tulada irügeküä ene buyu (Haenisch 1954:161b-162a Төмөртогоо Дамдинжав 1967: 51)

Uridanu jarlıqun yosu`ar č'an tamqa dača busi ali ba qubč'iri ülü üjen (Poppe 1957: 9-11 Төмөртогоо Дамдинжав 1967: 51)

Bi köün -neče-yen dorben külü`üd-i-činü huyuju ilebe bi (Haenisch 1962&163, Төмөртогоо Дамдинжав 1967: 51)

Harban nigädugär hon-nača (Lewicki 1949 IV 17b; Төмөртогоо Дамдинжав 1967: 50)

Qatayujin ene nom-i joqiyaydaysan-nača yaruysan habur-un naran metü buyan (Haenisch 1954 :166b 10 11, Төмөртогоо Дамдинжав 1967: 51)

Tämdäktäyä dzayaxdaxsan xaxan gü`ün-neče angida (Lewicki 1949 17 b; Төмөртогоо, Дамдинжав 1967: 51)

Монгол хэлний гаражын тийн ялгалын хэд хэдэн хэлбэр нь энэхүү нөхцлийн гарал үүслийг тогтооход чухал зүйл болно. Д Төмөртогоо Л. Дамдинжав нар гаражын тийн

<sup>1</sup> Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

ялгалыг утгын хувьд оршихын хувьд оршихын тийн ялгалтай холбоотой хэмээн үзсэн нь сонирхолтой бөгөөд гаражын тийн ялгалаас хэлбэр үүссэн тухайд тэд "...монгол хэлний гаражын тийн ялгалын эгшгээр эхэлсэн шинэ хувилбарт яагаад оршихын тийн ялгалыг авсан нь бас л нарийн учиртай юм. Аливаа гарах үйл нь гагцхүү орших орноос гарах тул тийнхүү оршихын тийн ялгал хэрэглэжээ гэсэн бол хэлбэрийн тухайд "... дундад үеийн монгол хэлэнд ачаа ийн бүрэлдэхүүнд буй а-ийн ийм орны утга алдагдаж улмаар -ачаа нь дан гаражын утгыг хэрэглэх болжээ. Энэ үеээс гарах орны утгыг орны тутгатай давхар илтгэхийн тулд -dača гэсэн хоёр дахь нийлэмж гарч иржээ " гэж өгүүлжээ.(Төмөртогоо, Дамдинжав 1967: 50-53)

Бид монгол хэлний гаражын тийн ялгал нь утгаа орших гарах гэсэн нэгдмэл тийн ялгалаас үүссэн гэдгийг түрэг хэлний баримт жишээтэй харгуулан гаргаж болно гэж бодож байна.

Юуны өмнө гадаад хэлбэрээс нь харвал монгол хэлний гаражын тийн ялгалын -čа хэлбэр, түрэг хэлний гаражын тийн ялгалын -da -dan, монгол түрэг хэлний оршихын тийн ялгалын -da -ta хэлбэр нь тохирч байна

(Алтай хэлний судалгаанд монгол хэлний болоод түрэг хэлний авиаг тохирдог хэмээн үздэг. Жишээ нь монгол хэлний čilayu, түрэг хэлний taš, монгол хэлний bičig, түрэг хэлний bitik)

Бид монгол хэлний гаражын тийн ялгал нь оршихын тийн ялгалтай гарал үүслийн талаас холбоо хэлхээтэй гэдгийг утгын үүднээс эртний түрэг хэлэнд байх - da -ta хэлбэр нь оршихын тийн ялгалын хэлбэр боловч орших гаражын тийн ялгалын үүрэг утгыг хамтатган агуулж байсан тул судлаачид орших гаражын тийн ялгал (Gabain Räsänen 1957:56-74) хэмээн нэрлэдэг билээ. Гэхдээ эртний түрэг хэлний нэгдмэл орших гаражын тийн ялгал нь энэхүү хэлбэрээрээ эртний болоод орчин үеийн зарим хэл аялгуунд тохиолдож байна. Үүнийг эрдэмтэд оршихын тийн ялгалын гарах үүрэг (Ergin 1997:46), эсвэл гаражын тийн ялгал (Korkmaz 2003: 23) хэмээн өөр өөрөөр нэрлэж байна. Хожим үүссэн түрэг хэлний гаражын тийн ялгалын нөхцөл буюу -dan -tan хэлбэрүүд ч энэ орших гарах тийн ялгалаас үүсч бий болжээ.

Түрэг хэлэнд -dan -tan хэлбэртэй гаражын тийн ялгал гарч ирснээр -da -ta хэлбэрт байсан гаражын утга нь -dan -tan хэлбэр лүү шилжсэн бөгөөд түрэг хэлний -da -ta хэлбэрт зөвхөн орших утга үлджээ. (Buran 1996 : 177)

Гэвч -da -ta хэлбэр нь эртний түрэг хэлний орших гарах утгын үргэлжлэл болон түрэг хэлний янз бүрийн үе шатанд төрөл бүрийн хэл аялгуст зөвхөн гарах эсвэл орших утгаараа заримдаа орших гарах утгаараа хэрэглэгдэж байна. (Buran 1996 : 177)

Энэхүү тийн ялгал нь түркмен, татар, үйгүр хэлэнд цаг орны, орон цагийн тийн ялгал, орчин цагийн түрэг хэлэнд оршихын тийн ялгал гэж нэрлэгдэж байна. (Buran 1996 : 177)

Ийнхүү монгол хэлний гаражын тийн ялгалыг түрэг хэлнийх лүгээ утга хэлбэр гарлын талаас харьцуулахад монгол хэлний гаражын тийн ялгал нь түрэг монгол хэлний гарах орших гэсэн нэгдмэл тийн ялгалаас үүссэн болох нь тодорхой байна.

## **Ном зүй**

- Зоригт Го, Элсэнцэг Монгол хэлний тийн ялгалын судлал Хөх хот 2001  
Поппе Н. Монгольский словарь Мукааддимат Ал Адаб М Л 1938  
Поппе Н. Грамматика письменного монгольского языка М Л 1937  
Санжеев Г. Д. Сравнительная грамматика монгольских языков М 1953  
Сэргээ Ж, Амаржаргал Б., Монголын нууц товчооны хэлний тийн ялгалын тогтолцоо Хэл зохиол судлал боть Улаанбаатар 1987  
Төмөртогоо Д. Дамдинжав Л., Эртний монгол хэлний гарахын тийн ялгалын дагаврын нэгэн хувилбар Монголын судлал 6 боть Улаанбаатар 1967  
Buran A, Anadolu Agızlarında İsim Çekim /Hal/ Ekleri Ankara 1996  
Cleawes F . W. The Sino-Mongolian inscription of 1338 in Memory of Jiguntei HJ(AS)1951 vol. XIV  
Cleawes F . W. The Sino-Mongolian inscription of 1362 in Memory of Prince Hindu HJ(AS)1949 vol. XII Ergin M. Türk Dil Bilgisi İstanbul 1997  
Gabain A, von Alttürkische Grammatik Leipzig 1941  
Haenisch E, Monghol-un ni`uca tobca`an Wiesbaden1962  
Haenisch E, Mongolica der Berliner Turfan Sammlung 1 Ein Buddistisches Druckfragment von Jahre 1312 Berlin 1954  
Korkmaz Z, Türkiye Türkçesi Grameri Şekil Bilgisi Ankara 2003  
Lewicki M, La langue Mongole des transcriptions Chinoise du XIV siecle Hoya-yi-yi-yu de 1389, t 1, Wroclaw, 1949  
Poppe N, Introduction to Mongolian comparative studies Helsinki 1955  
Poppe N, The Mongolian Monument in HP`ags-pa script, Wiesbaden 1957  
Räsänen M, Materialen zur Morphologie der Türkischen Sprachen Helsinki 1957

## **SUMMARY**

The author discusses on the genesis of the Mongolian ablative case in comparison with the facts of the Turkish language. According to the author Mongolian ablative case -ча formed as a continuation of the ancient Turkic-Mongol locative – ablative case -та /тан/.